

ЭРДЭНЭЦАГААН СУМ

2021 ОНЫ 10 ДУГААР САРЫН МЭДЭЭ

Хууль эрх зүй, удирдлага зохион байгуулалтын хүрээнд:

Ахмадын баярыг тохиолдуулан Ахмадуудадаа “Төсөвт байгууллагууд болон ХХҮ”-ний газраас 566 ахмадад хүндэтгэл үзүүлж ажилласан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Талархлын концертыг” зохион байгуулахад сумын ЗДТГ-аас дэмжлэг үзүүлж зохион байгууллаа.

2021 оны ээлжит цэрэг татлагын үзлэгийг аймаг суманд амжилттай зохион байгуулж 2020 оны 2-р ээлжийн цэрэгт явсан 26 ЦЖА-ийг хүлээн авч, цэргийн насны 59 залууг шат шатны үзлэгт хамруулж 32 залууг ХЦ-ийн 0132, Зэвсэгт хүчний 328, Ардын армийн 388 дугаар ангиудад хуваарилуулан ЦЖА-нд мордууллаа.

Малын гоц халдварт өвчний шинж тэмдэг илэрсэтэй холбогдуулан сумын 6,7 дугаар багийн нутаг дэвсгэрт хязгаарлалтын дэглэм тогтоож газар нутгийг тэмдэгжүүлж хот малын ариутгал хийж зарим хэсгийг вакцинжуулах зэрэг яаралтай арга хэмжээг Мал хамгаалах сангаас 2.5 сая төгрөгийн зардал гарган ажиллаа.

АЗД-ын захирамжаар зохион байгуулагдсан “Худалдааны байгууллагын 100” жилийн ойн арга хэмжээнд Ахмад туршлагатай манлай худалдагч, Нийтийн хоолны тогооч, НАҮ-ний гуталчин, Шилдэг үйлдвэрлэгч, шилдэг Худалдаачин нарыг зохион байгуулалттайгаар оролцуулж шагнаж урамшуулсан.

Сумын өндөр настан, ХБИ, өрх толгойлсон эмэгтэй зэргийн судалгааг баг бүрээр гаргаж “тус бүр нь 2 тн” нүүрсний туслалцаа үзүүлэх ажлыг бэлтгэж байна.

Төрийн Хяналт Шалгалтын тухай хууль, Сумын Дотоод Хяналт шалгалтын хүрээнд Зөвшөөрөлгүй хадлан хадсан гэх гомдлын дагуу 3 хадланд шалгалт хийж зөрчлийг тогтоож холбогдох байгууллагат шилжүүлж ажиллаа.

Шинээр сонгогдсон томилогдсон Долоон БЗД нарт Төрийн албан анхан шатны мэдлэг олгох богино хэмжээний сургалтыг зохион байгуулж, тэдгээрийн анкет бүрдүүлэлт, төлөвлөгөө боловсруулж тайлан бичих, бланк ашиглах зэргийг зааж сургалаа.

Багийн Засаг дарга, Татвар, Нийгмийн даатгал, Байгаль орчин, Мал эмнэлгийн улсын байцаагч, ГУА-47 дугаар анги зэргийн албан хаагчдын төлөөллийг оролцуулан сумын төв болон хөдөөгийн багт цаг үеийн ажлаар бүлэг ажиллуулсан.

ЕБС: Туршлагаа хуваалцъя, түгээн дэлгэрүүлъя 21 хоногийн аяны хүрээнд багш ажилтан бүр тасралтгүй хөгжих, мэдээлэл харилцаа холбооны техник технологийн ур чадвараа сайжруулах ээлжит хичээлийн хөтөлбөрийг чанартай бэлтгэж нээлттэй хэлэлцүүлэгт хичээлүүд заагдаж эхэлсэн.

Олон улсын охидын эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан байрын охидуудад “Охидын эрх хамгаалал ба харилцаа, хандлага” сэдвийн хүрээнд яриа таниулга хийж идэвхжүүлэх болон анхаарал шалгах тоглоом чанга шивнээ, загварын ертөнц зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж, 7-12-р ангийн 17 бүлгийн нийт 263 охидуудад “Охидын үнэ цэнэ”, “Би хэн бэ?”, Өөрийгөө таньж мэдэхийн учир, цахим орчны зөв зохистой хэрэглээ, эерэг харилцаа хандлага, биеэ зөв авч явах соёл зэрэг сэдвүүдээр яриа таниулга хийж, 9-12-р ангийн 17 сурагчтай ганцаарчилсан уулзалт ярилцлагыг хийж зөвлөгөө зөвлөмж өгч ажилласан.

Өсвөрийн эмч клубын сурагчид хамтран Дэлхийн гар угаах өдрийг тохиолдуулан “Цэвэр гар-зөв дадал видео бичлэг, зөвлөмж, уриалга, гар зургийн уралдааныг зохион байгуулж идэвх санаачлагатай оролцсон анги бүлгүүдийг шагнаж урамшуулсан.

Засгийн газраас жил бүрийн 09 дүгээр сарын сүүлийн 7 хоногийн лхагва гаригийг “Сурагчдын сүүний өдөр” болгон хүүхэд бүрт нэг аяга сүү аянд нэгдэж лхагва гараг бүр сурагчдынхаа дархлааг дэмжин сүү сүүн бүтээгдэхүүнийг өгч байна.

Гамшгийн эрсдэл бууруулах олон улсын өдрөөр байрын сурагчдад Газар хөдлөлт гэж юу вэ?, газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулсан. Мөн багш ажилчдад “Хуримтлал яаж үүсгэх”, “Гэр бүлийн эерэг харилцаа” сэдвээр цахим сургалтыг зохион байгуулсан.

Боловсролын үнэлгээний төвөөс “Сургуульд суурилсан үнэлгээ” оношилгоог 2-12-р ангийн бүх судлагдахуунаар амжилттай зохион байгуулсан.

School police эцэг эхийн эргүүл хуваарийн дагуу сургууль орчмын бүсэд зам тээврийн осол, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, үе тэнгийн хүчирхийлэлд хүүхэд өртөх, тээврийн хэрэгслийг зогсоолд зогсоох мөн сурагчдыг тээврийн хэрэгслийн өмнүүр гүйхгүй байхыг анхааруулж ажиллаж байна.

Аймгийн ГБХЗГ-аас “Ирээдүйн эзэд 2021” мэргэжил сонголтын аяны хүрээнд зохион байгуулсан мэргэжлээ хэрхэн сонгох вэ? цахим сургалтанд 8-12-р ангийн сурагчид бүгд хамрагдсан.

Мобиком корпорацийн хүүхдийн боловсролыг дэмжих, боловсролын тэгш хүртээмжтэй байдлыг хангах зорилгоор санаачлан хэрэгжүүлж буй "Smart

Education" төслийн уралдаанд сурагч С.Алтанцэцэг зургийн бүтээлээрээ оролцож шилдэг 40 хүүхдэд шалгарч Samsung Galaxy M12 гар утас болон бүтэн жилийн турш VOO үйлчилгээний 30 хоногийн багц, CAP БҮР 3. GB дата багц, аав ээжтэйгээ ҮНЭГҮЙ ярьдаг stars үйлчилгээний дугаараар шагнагдсан.

Монгол улсад Залуучуудын байгууллага үүсч хөгжсөний 100 жилийн ой, Орчин үеийн зэвсэгт хүчин үүсгэн байгуулагдсаны 100 жилийн ой, залуучуудын хөгжлийн сарын аяны хүрээнд “Эх орон 100”, “Энхийг сахиулагчид ба хөвгүүд” цахим уулзалтанд ахлах ангийн сурагчид сургуулиа төлөөлж оролцсон.

Улирлын томуу, томуу төст өвчлөлөөс урьдчилан сэргийлэх вакциныг зохион байгуулж 6-11 насны нийт 541 сурагчид хамрагдсан.

Нийгмийн даатгал: Сайн дурын даатгалд шинээр 16 иргэнийг хамруулж гэрээ байгуулан, 7 иргэнд тэтгэвэр тогтоож, 2021.01.01-нээс эхлэн шинээр хэрэгжиж буй Ажилласан жил нөхөн тооцох хуульд 5 иргэний материалыг хүлээн авч 12.5 сая төгрөгийн орлого оруулсан.

Хүн ам зүй: Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 2 өрхийн ар гэр болон сургууль цэцэрлэгт сурч байгаа хүүхдүүдийн ангийн багш нартай нь уулзаж хүүхдүүдийн асуудлаар ярилцсан. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хяналтанд байгаа 1 кейсийг хаах саналын дагуу матеиралыг бүрдүүлж байна. ГБХ болон Хүүхэд хамгааллийн чиглэлээр энэ сард нийт 6 иргэнд зөвлөгөө зөвлөмж өгч ажилласан байна. НТБТ-д 16-45 насны боловсролгүй 114 иргэдийн судалгааг баг бүрээр түүвэрлэн өгөхөд үүнээс 42 нь ХБИ байна.

Эрүүл мэнд: Эрүүл мэндийн төвд хүчилтөрөгчийн өтгөрүүлсэн аппарат төрөл бүрийн эх үүсвэрээс шинээр 5 –ыг нийлүүлсэн. Сумын хэмжээнд 3-р тун вакцинд 832 иргэн хамрагдаж 20.7% тай байна. 3-р тун вакцинд хамрагдаагүй ТАХ-ын судалгааг шалтгаантай нь гаргаж АОК-д хүргүүлээд байна.

Хөдөө аж ахуй: Газар тариалалтын тухайд 250 га-д үр тариа, 1800 га-д тэжээлийн ургамал тариалж 193.5 тн үр тариа, будаа, 274 тн тэжээлийн ургамал хураан авч уранш 1000 га талбайд хийж ажилласан. Төмс 10 га газраас 9.8 тн, хүнсний ногоо 4.7 тн-ыг хураан авсан.

Төрийн мэдлийн богийн хээлтүүлэгч 26 хуц, 10 ишгэн ухныг иргэдэд олголоо. Өвс тэжээлийн нөөцөд 3500 боодол өвс буулган, “Бор өндөр”-ийн хадлангаас 1300 өвсийг 2,3,4,5,6,8-р багийн 55 малчин өрхөд олгосон. Мөн 4,6,7 дугаар багийн нутаг дэвсгэрт гарч буй хадлангуудаас хөдөөгийн малчин өрхийн 40% нь өвс татаж аваад байна.

4-н багийн 1200 толгой малд ангилан ялгалт хийн, төлөвлөлтөөс 584 толгой мал дутуу байна.

ХХААЯ, ХААИС-аас зохион байгуулсан “Бэлчээрийн ургамал, хөрс хамгаалал” “хадлан тэжээл бэлтгэлт” сэдэвт 5 хоногийн цахим сургалт, аймгийн ХХААГ-ын мал аж ахуйн хэлтсээс 8 цагийн цахим сургалтанд ХАА,Хүнс худалдаа Мал эмнэлгийн мэргэжилтэнгүүд хамрагдлаа.

Газар тариалалтын тухайд 250 га-д үр тариа, 1800 га-д тэжээлийн ургамал тариалж 193.5 тн үр тариа,будаа, 274 тн тэжээлийн ургамал хураан авч уранш 1000 га талбайд хийж ажилласан. Төмс 10 га газраас 9.8 тн, хүнсний ногоо 4.7 тн-ыг хураан авсан.

Тайлан бичсэн ХЭЗ,ДХ- хариуцсан мэргэжилтэн

Б.Энхтуяа.